

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 7418 дугаарт бүртгэв.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/492

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гаалийн тухай хуулийн 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.11, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 заалт, Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 10/01 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн), харьяа гаалийн газар, хороодын дарга нарт тус тус даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Б.Хосбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

*Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны
10 дугаар сарын 27-ны өдрийн
А/492 дугаар тушаалын хавсралт*

**АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭХЭД
ТУСГАЙЛАН ТАВИХ ШААРДЛАГА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ТЭЭВЭРЛЭЛТИЙН ӨМНӨХ АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн хилээр амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага, хилээр нэвтрүүлэхээс өмнөх болон нэвтрүүлэх үед тээврийн хэрэгслийг ариутгаж, халдваргүйжүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийг ариутгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) -ын Газрын амьтны эрүүл мэндийн кодекс, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005), Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээр (SPS), Ургамал хамгааллын олон улсын конвенц (IPPC)-ид заасан шаардлага, зөвлөмжид нийцсэн байна.

1.3.Тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн ариутгалын ажилтан хийж гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд харьяа гаалийн газар, хороодоос хяналт тавина.

Хоёр. Тээвэрлэлтэд тавих тусгай шаардлага, чиг үүрэг

2.1.Мал, амьтныг тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.иргэн, хуулийн этгээд нь гаалийн хилээр нэвтрүүлэх мал, амьтны талаарх мэдээллийг харьяа гаалийн газар, хороодод `serp.gaali.mn` системээр 24 цагийн өмнө өгсөн байх;

2.1.2.импортлогч иргэн, хуулийн этгээд нь мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй, голомт үүсээгүй тайван улс, бүсээс тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон мал эмнэлгийн гэрчилгээтэйгээр тээвэрлэх;

2.1.3.мал, амьтныг улсын хилээр нэвтрүүлэх үед харьяа гаалийн газар, хороодын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчаар эрүүл мэндийн үзлэгийг хилийн гаалийн хяналтын бүсэд хийлгүүлэх;

2.1.4.тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийг технологийн дагуу цэвэрлэн, ариутгаж, халдваргүйжүүлснийг нотолсон гэрчилгээг экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас авсан байх;

2.1.5.тээврийн хэрэгсэл нь агааржуулалтын болон хэмийн тохируулгатай, эд анги, тоноглол нь мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй материалаар хийгдсэн, тавлаг байдлыг хангасан, нэг нэгийгээ гэмтээхгүй нөхцөлтэйгээр тээвэрлэгдсэн байх;

2.1.6.тээвэрлэлтийн явцад мал, амьтныг хооллох, арчлах, үзлэг, эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн, ачиж буулгах тоноглол нь гулгалт, халтиргаа үүсгэхгүй байх;

2.1.7.тээвэрлэлтийн явцын маршрутын бүртгэл, тэмдэглэгээтэй байх;

2.1.8.тээвэрлэлтийн хугацаанд өвдсөн, гэмтэж бэртсэн, хөдөлгөөний бэрхшээлтэй болсон мал, амьтныг тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд харьяа гаалийн газар, хороодын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчид нэн даруй мэдэгдэж, түүний хяналт дор мал эмнэлгийн байгууллагад шилжүүлэх;

2.1.9.мал, амьтныг газраар болон агаараар тээвэрлэхэд тавигдах бусад тусгай шаардлага нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) -ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн кодексын 7 дугаар бүлгийн 3, 4 дэх хэсэгт заасан зөвлөмж, шаардлагад нийцсэн байх.

2.2.Мал, амьтныг хилээр нэвтрүүлэн тээвэрлэх үед харьяа гаалийн газар, хороодын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1.мал, амьтныг улсын хилээр нэвтрүүлэх үед эрүүл мэндийн үзлэгийг хилийн гаалийн хяналтын бүс, талбай, хорио цээрийн байгууламжид хийх;

2.2.2.экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг шалгах;

2.2.3.эрүүл мэндийн үзлэг, шалгалтаар халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн мал, амьтнаас дээж авч, магадлан шинжилгээнд хамруулан баталгаажуулж, хорио цээрийн байгууламж, бүсэд түр тусгаарлан, тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд, гаалийн газар, хороод болон гаалийн удирдах дээд байгууллага, мал эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэх;

2.2.4.магадлан шинжилгээгээр мал, амьтны гоц халдварт өвчний тохиолдол батлагдсан үед хорио цээрийн дэглэмд оруулж, түр тусгаарлан, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад шилжүүлэх;

2.2.5.өвчний шинж тэмдэг бүхий мал амьтныг тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл, тоноглол, ялгас, хавьтал болсон талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, хяналт тавих;

2.2.6.мал, амьтны гоц халдварт өвчнөөр өвчилсөн амьд, мал амьтныг экспортлогч талын мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, хуулийн дагуу буцаах, эсвэл тээвэрлэгч иргэн, хуулийн этгээдийн байлцуулан устгуулах арга хэмжээнд оролцож, хяналт тавих.

2.3.Мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1.мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд нь тээврийн хэрэгслийг улсын хилээр оруулахаас өмнө ceps.gaali.mn системээр гаалийн байгууллагад мэдэгдэх;

2.3.2.тээвэрлэхийн өмнө тээврийн хэрэгсэлд хийгдсэн ариутгал, халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авсан байх;

2.3.3.импортын мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн дэгдэлт гараагүй тайван улс, бүсээс тээвэрлэсэн байх;

2.3.4.мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ариун цэвэр, эрүүл ахуй шаардлага хангасан, халуун, хүйтний хэмийн тохируулгатай тээврийн хэрэгслээр холбогдох стандартуудад нийцүүлэн тээвэрлэх;

2.3.5.задгайгаар болон багцалж тээвэрлэсэн ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ачсан тээврийн хэрэгсэл нь гадны бохирдол, ус чийгнээс хамгаалсан битүүмжлэлтэй, зориулалтын бүтээлэгтэй байх;

2.3.6.барааны өрөлт, хураалтыг холбогдох стандартад нийцүүлж, үзлэг шалгалт хийх, сорьц авах нөхцөлийг бүрдүүлэх, тээвэрлэлт, хадгалалтын горимын ялгаатай барааг хольж тээвэрлэхгүй байх;

2.3.7.түргэн гэмтэх болон хэмийн горим шаарддаг бараанд хадгалалт, тээвэрлэлтийн үеийн бүртгэл, тэмдэглэгээг хөтөлсөн байх;

2.3.8.экспортын мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл нь импортлогч улсаас тавигддаг тээвэрлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн нөхцөл шаардлагыг хангасан байх;

2.3.9.мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих бусад тусгай шаардлага нь

холбогдох стандарт, мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журам, зааварт нийцсэн байх.

2.4.Мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэн тээвэрлэх үед гаалийн газар, хороодын чиглэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4.1.тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авсан эсэхийг шалгаж, баталгаажуулах;

2.4.2.ургамал, ургамлын гаралтай түүхий эд, тарих үрийн материалыг хилийн гаалийн хяналтын бүсэд оруулмагц тэдгээрт хийх анхдагч үзлэгийг тээвэрлэлт, хадгалалтын нөхцөлтэй уялдуулан хийх;

2.4.3.мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр барааны хаяг шошго дээр бичсэн хэмийн горимд нийцүүлэн тээвэрлэсэн эсэхэд хяналт тавих;

2.4.4.магадлан шинжилгээгээр мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн шаардлага хангаагүй барааг ариутгаж, халдваргүйжүүлэх, буцаах, устгах арга хэмжээ авах;

2.4.5.ургамлын дотоод цээртэй зүйлс илэрсэн бараанд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх, хяналт тавих;

2.4.6.хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөн, илт муудаж, хөлдөж гэмтсэн эсвэл магадлан шинжилгээний дүнгээр хорио цээр, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй болох нь нотлогдсон тохиолдолд экспортлогч талын эрх бүхий байгууллагад мэдээлж буцаах, эсвэл тээвэрлэгч иргэн, хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулан устгуулах арга хэмжээг зохион байгуулах.

Гурав. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн шаардлага, чиг үүрэг

3.1.Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, ариутгалын ажилтан дараах шаардлагыг мөрдөж ажиллана.

3.1.1.улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх заавар батлагдсан, хүчинтэй хугацаатай, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, хаяг шошго нь тодорхой бодисыг ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэх;

3.1.2.тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг шүрших, туулуулах, мананцаржуулах, уураар утах, хэт ягаан туяагаар шарах зэрэг хими, физикийн аргуудыг дангаар болон хослуулан хийх;

3.1.3.ариутгал, халдваргүйжүүлэлтийн уусмал бэлтгэх, өмсгөл, баг, хошуувч, амны хаалт, бээлий, хормогч зэрэг зориулалтын хувийн хамгаалах хувцсыг тухайн бодисын төрлөөс хамаарч сонгож хэрэглэх;

3.1.4.ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгалах;

3.1.5.халдварт өвчин тархсан, голомттой бүсээс ирсэн тээврийн хэрэгсэл, халдвартай болох нь нотлогдсон мал, амьтан, ургамлын хорио цээртэй зүйлс илэрсэн бараанд хийгдэх ариутгал, халдваргүйжүүлэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан журам, зааварт нийцүүлэн хийх.

3.2.Харьяа гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1.мал, амьтан тээвэрлэн ирсэн тээврийн хэрэгсэл, тоноглол, эд зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх үед урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтэд хамруулж, хяналт тавих;

3.2.2. мал, амьтныг нэг тээврийн хэрэгслээс нөгөө тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачилт хийх болон дамжуулан өнгөрүүлэх нөхцөлд тээврийн хэрэгслийг урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтэд хамруулахад хяналт тавих;

3.2.3.үзлэг, магадлан шинжилгээгээр халдвартай болох нь оношлогдсон мал, амьтан, ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, тэдгээрийн өндөг, авгалдай илэрсэн тохиолдолд тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар тээврийн хэрэгсэл, тоноглол, бараа, сав баглаа боодол, агуулах, талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгүүлж, хяналт тавих;

3.2.4.ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны чанар, бодисын хадгалалт, гаалийн баталгаат агуулах, талбайн шавж, мэрэгчийн устгал болон хатуу, шингэн тусгай хог хаягдлын зайлуулалтад хяналт тавих;

3.2.5.тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэлийг гаалийн байгууллагын Хорио цээрийн мэдээллийн удирдлагын систем /QIMS/-ээр хөтөлж, тайлагнах.

3.3.Харьяа гаалийн газар, хороодын удирдлага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1.ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг хилийн хөдөлгөөний урсгалд саад болохгүйгээр зохион байгуулж, ариутгалын байгууламж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангуулж ажиллах;

3.3.2.ариутгалын ажилтанг мэргэжлийн байгууллагатай хамтран сургалтад хамруулж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгал,

халдваргүйтгэлийн бодис, урвалж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, хор саармагжуулах бэлдмэлээр тогтмол хангаж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байх;

3.3.3.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал (олон улсын хөл хориот хүний өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, цацраг, химийн осол хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт гэх мэт) хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд үүссэн үед тээврийн хэрэгсэл, барааны ариутгал, халдваргүйжүүлэлтийг онцгой байдлын үед ажиллах үеийн горим, холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан журам, зааварт нийцүүлэх;

3.3.4.тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлж болно.

Дөрөв. Хариуцлага

4.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ТӨВИЙН УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ЦЭВЭР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын төвийн ус түгээх байрны цэвэр усны үйлчилгээний тарифыг НӨАТ-гүй 1.82 төг/л-ээр баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг дарга /М.Баярсүх/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Дундговь аймгийн сумдыг ус хангамжийн үйлчилгээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг “Дундговь ус” ОНӨААТҮГ /Т.Мөнхбаяр/-т даалгасугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 7420 дугаарт бүртгэв.

ЗАВХАН АЙМГИЙН САНТМАРГАЗ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 01

Холбоо

БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.23 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.14 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.6 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1.Сумын бэлчээр ашиглалтын талаар нийтээр дагаж мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Баярмаа)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Өнаржаргал) -д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БАЛСАН



இந்தியா -

ਅੰਤਰਿਕਸ਼ੀਨੀ ਸਮਾਜਿਕ ਨਿਆਂ ਦੀ ਪ੍ਰਵਰਤਨਾ

२. ॐ नमो भगवते वासुदेवाय ॥

$(6.6 \times 10^{-27}) \times 2.5 \times 10^8 = 1.65 \times 10^{-18} \text{ kg}$

[illegible]

(Handwritten signature)

2. 105 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31 32 33 34 35 36 37 38 39 40 41 42 43 44 45 46 47 48 49 50 51 52 53 54 55 56 57 58 59 60 61 62 63 64 65 66 67 68 69 70 71 72 73 74 75 76 77 78 79 80 81 82 83 84 85 86 87 88 89 90 91 92 93 94 95 96 97 98 99 100 101 102 103 104 105 106 107 108 109 110 111 112 113 114 115 116 117 118 119 120 121 122 123 124 125 126 127 128 129 130 131 132 133 134 135 136 137 138 139 140 141 142 143 144 145 146 147 148 149 150 151 152 153 154 155 156 157 158 159 160 161 162 163 164 165 166 167 168 169 170 171 172 173 174 175 176 177 178 179 180 181 182 183 184 185 186 187 188 189 190 191 192 193 194 195 196 197 198 199 200 201 202 203 204 205 206 207 208 209 210 211 212 213 214 215 216 217 218 219 220 221 222 223 224 225 226 227 228 229 230 231 232 233 234 235 236 237 238 239 240 241 242 243 244 245 246 247 248 249 250 251 252 253 254 255 256 257 258 259 260 261 262 263 264 265 266 267 268 269 270 271 272 273 274 275 276 277 278 279 280 281 282 283 284 285 286 287 288 289 290 291 292 293 294 295 296 297 298 299 300 301 302 303 304 305 306 307 308 309 310 311 312 313 314 315 316 317 318 319 320 321 322 323 324 325 326 327 328 329 330 331 332 333 334 335 336 337 338 339 340 341 342 343 344 345 346 347 348 349 350 351 352 353 354 355 356 357 358 359 360 361 362 363 364 365 366 367 368 369 370 371 372 373 374 375 376 377 378 379 380 381 382 383 384 385 386 387 388 389 390 391 392 393 394 395 396 397 398 399 400 401 402 403 404 405 406 407 408 409 410 411 412 413 414 415 416 417 418 419 420 421 422 423 424 425 426 427 428 429 430 431 432 433 434 435 436 437 438 439 440 441 442 443 444 445 446 447 448 449 450 451 452 453 454 455 456 457 458 459 460 461 462 463 464 465 466 467 468 469 470 471 472 473 474 475 476 477 478 479 480 481 482 483 484 485 486 487 488 489 490 491 492 493 494 495 496 497 498 499 500 501 502 503 504 505 506 507 508 509 510 511 512 513 514 515 516 517 518 519 520 521 522 523 524 525 526 527 528 529 530 531 532 533 534 535 536 537 538 539 540 541 542 543 544 545 546 547 548 549 550 551 552 553 554 555 556 557 558 559 560 561 562 563 564 565 566 567 568 569 570 571 572 573 574 575 576 577 578 579 580 581 582 583 584 585 586 587 588 589 590 591 592 593 594 595 596 597 598 599 600 601 602 603 604 605 606 607 608 609 610 611 612 613 614 615 616 617 618 619 620 621 622 623 624 625 626 627 628 629 630 631 632 633 634 635 636 637 638 639 640 641 642 643 644 645 646 647 648 649 650 651 652 653 654 655 656 657 658 659 660 661 662 663 664 665 666 667 668 669 670 671 672 673 674 675 676 677 678 679 680 681 682 683 684 685 686 687 688 689 690 691 692 693 694 695 696 697 698 699 700 701 702 703 704 705 706 707 708 709 710 711 712 713 714 715 716 717 718 719 720 721 722 723 724 725 726 727 728 729 730 731 732 733 734 735 736 737 738 739 740 741 742 743 744 745 746 747 748 749 750 751 752 753 754 755 756 757 758 759 760 761 762 763 764 765 766 767 768 769 770 771 772 773 774 775 776 777 778 779 780 781 782 783 784 785 786 787 788 789 790 791 792 793 794 795 796 797 798 799 800 801 802 803 804 805 806 807 808 809 810 811 812 813 814 815 816 817 818 819 820 821 822 823 824 825 826 827 828 829 830 831 832 833 834 835 836 837 838 839 840 841 842 843 844 845 846 847 848 849 850 851 852 853 854 855 856 857 858 859 860 861 862 863 864 865 866 867 868 869 870 871 872 873 874 875 876 877 878 879 880 881 882 883 884 885 886 887 888 889 890 891 892 893 894 895 896 897 898 899 900 901 902 903 904 905 906 907 908 909 910 911 912 913 914 915 916 917 918 919 920 921 922 923 924 925 926 927 928 929 930 931 932 933 934 935 936 937 938 939 940 941 942 943 944 945 946 947 948 949 950 951 952 953 954 955 956 957 958 959 960 961 962 963 964 965 966 967 968 969 970 971 972 973 974 975 976 977 978 979 980 981 982 983 984 985 986 987 988 989 990 991 992 993 994 995 996 997 998 999 1000 1001 1002 1003 1004 1005 1006 1007 1008 1009 1010 1011 1012 1013 1014 1015 1016 1017 1018 1019 1020 1021 1022 1023 1024 1025 1026 1027 1028 1029 1030 1031 1032 1033 1034 1035 1036 1037 1038 1039 1040 1041 1042 1043

ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥

המחבר מודה לרבותאם שכתבוהו וליהודים שכתבוהו

6. *Handwritten text in Devanagari script, likely a signature or date.*

[Handwritten signature]

[Handwritten signature]

[illegible]

മെഴുത്തു തൊഴിലിൽ താല്പര്യം വർദ്ധിക്കുന്നു

ਦੇਵਦੇਵ ਸ੍ਰੀ ੭੦ ਸ੍ਰੀ ੭੦ ਸ੍ਰੀ

ପ୍ରାୟ ୦୭

ਗਿਆਨੀ



ਸੁਰਮਿਓਤਾਨੁ 6 ਚਰਮਿਓਤਾਨੁ

[illegible]

2. $\frac{1}{2} \times \frac{1}{2} = \frac{1}{4}$

የጥቅም ጥገና ዓላማ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит
5 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралт*

САНТМАРГАЗ СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Бэлчээрийг орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар улирлын хуваарьтай төлөвлөх, бэлчээрийн даац, багтаамжид тохируулан малын тоо толгойн зохистой хэмжээг бий болгож, бэлчээр байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалахад нутгийн захиргаа, малчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулахад оршино.

1.2.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал чанарыг хадгалах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагших, давсжих, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.

1.3.Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү журмыг мөрдлөгө болгон ажиллана.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтлана.

2.1.1.Бэлчээрийн даац, багтаамж, экологийн чадавхид суурилах

2.1.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө /цаашид “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1.Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний /фотомониторинг гэх/ дүнд үндэслэсэн байх

2.2.2.Бэлчээрийг улирлаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарь гаргах

2.2.3.Тариалангийн талбайгаас 500-1000 метрээс гадагш байх

2.2.4.Уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

2.2.5.Бэлчээр ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улс, донор байгууллагын төсөл хэрэгжүүлэгч нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллах

Гурав. Бэлчээрийн даац тооцох

3.1.Энэ журмын 4.7.1 дахь заалтын дагуу тодорхойлно.

3.2.Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 05-ныөдрийн А/113, А/250, А/422 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ын дагуу тооцно.

Дөрөв. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.Багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн Газрын тухай хуулийн 20.1.2, 52.6-д заасны дагуу сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн тусгайлан (өвөлжөө, хаваржаа, хадлангийн талбай, отрын, өнжөөх, чөлөөлөх) болон нийтээр (зуслан, намаржаа, худаг, нуур, булаг, хужир) ашиглах бэлчээрийн заагийг газрын зурагт тэмдэглэн 5, 9 сард тогтоож сумын Засаг дарга өргөн мэдүүлснийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.1.2.Сумын бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, хөрсний доройтолд оруулахаас урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг нь сурталчилан таниулах сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, бэлчээрийн даацад нийцсэн сүргийн зохистой бүтэцтэй байж, малын тоо, толгойг зохих түвшинд өсгөхийн ач холбогдолын талаар багийн Засаг дарга, малчидтай хамтран ажиллаж үр дүнг хэлэлцэж байхаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

4.1.3.Бэлчээр ашиглалтын журмыг үлгэр жишээ мөрдөж буй малчдыг бодлогоор дэмжих, шагнаж урамшуулах

4.2.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1.Бэлчээр болон ус ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулах, шалгах, тайлагнах

4.2.2.Багийн Засаг даргын жилийн ажлыг үнэлэхдээ энэ журмын хэрэгжилтийн үр дүнг тооцох

4.2.3.Гол, горхи, булаг, шандын эх ундарга, хадлангийн болон тариалангийн талбай хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах сургалтыг зохион байгуулах

4.2.4.Энэ журмын 4.2.7-д заасан гадны болон орон нутгийн отрын малд “Малын тоо толгойн албан татвар”-ыг ногдуулан төлсний дараа нутаглах бэлчээр, усыг зааж өгөх

4.2.5.Гантай эсхүл өвөлжилт хүндэрсэн өөрийн сумын багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй багийн нутаг дэвсгэрт айл өрх мал сүргийг тухайн багийн Засаг даргатай зөвшилцөн оруулах шийдвэр гаргах

4.2.6.Малчид, малчдын бүлэгт нэг наст болон олон наст ургамал тариалах, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй төрөлжүүлэн хөгжүүлэх зэрэгт бодлогоор дэмжих, арга зүйгээр хангах

4.2.7.Гаднаас ирсэн малчидтай “Бэлчээр ашиглуулах гэрээ” байгуулна.

4.2.8.Газрын тухай хуулийн 52.2 заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, мал оруулах хугацаа болон отроор ирсэн малчдад болзолт гэрээгээр бэлчээр ашиглуулж болно. Болзолт гэрээний төлбөрийг малчинтай тохирно.

4.2.9.Бэлчээрт мониторингийн судалгаа хийх, үүлэнд нөлөөлөх генератор байрлуулах саналыг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлж болно.

4.3.Багийн Иргэдийн Нийтийн Хурлаас дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1.Энэ журмын 2.2-д заасны дагуу төлөвлөгөөний төслийг сумын ХАА-н тасагтай хамтран боловсруулж хурлаараа хэлэлцэн жил бүрийн 5, 9 сарын 5-нд багтаан сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хуралд хүргүүлэх

4.3.2.”Бэлчээр ашиглалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа сумын Засаг даргад уламжлах, бэлчээр, усны маргаантай асуудлыг шалгаж, шийдвэрлэх

4.3.3.Уг журмын хэрэгжилтийн талаарх багийн Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэж, шийдвэр гаргах

4.4.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.1.Сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн өөрийн багийн нутаг дэвсгэрт тусгайлан болон нийтээр ашиглах бэлчээр усны хуваарь, заагийг газрын зурагт хот айл, малчдын бүлэг (цаашид бүлэг гэх) тус бүрээр нарийвчлан үйлдэн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах

4.4.2.Малчид болон малчдын бүлэгтэй “Бэлчээр ашиглалтын гэрээ” байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хянах, мэдээ мэдээллээр хангах

4.4.3.Гадны аймаг, сумаас (отор, гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн үйлчилгээний бичиг)-гүй орж ирсэн малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх, нутаг бэлчээр олгохгүй байх

4.4.4.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлын хүрээнд тандалт судалгааг малчид болон малчдын бүлэгтэй хамтран хийж, сумын Хөдөө аж ахуйн тасаг болон нийтийг хамруулан тэмцэх ажлыг зохион байгуулах

4.4.5.Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, үүлдэр угсаа, шилэн сонголт, чанар сайжруулахад анхаарч ажиллах, мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд малчдыг бүрэн хамруулах

4.4.6."Бэлчээр ашиглалтын журам" зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгч, сумын Засаг даргад нэн даруй мэдэгдэх

4.5.Сумын Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1.Сумын нийт мал сүргийг элдэв паразит шимэгч хорхой халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах

4.5.2.Малын шилжилт хөдөлгөөн мал амьтны гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр аюулгүй байдалд баталгаажуулалтын хяналт, тогтмол хийх

4.5.3.Гадны нутгаас болон отрын малд гарал үүсэл, эрүүл ахуй, мал эмнэлэгийн тасгийн байцаагчийн тодорхойлолтыг үндэслэх, шаардлагатай гэж үзвэл ариутгал халдваргүйжүүлэлт хийж сумын хилээр нэвтрүүлэх

4.6.Сумын Хөдөө аж ахуйн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

4.6.1.Малчдад бэлчээр ашиглалтын ач холбогдлыг ойлгуулж, мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх сайжруулах талаар сургалт зохион байгуулах бэлчээрийг зөв зохистой ашиглах дадалтай болгох

4.6.2.Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг тухайн багийн бэлчээр ашиглалтын хуваарийн төсөлд тусгуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

4.6.3.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, бэлчээр ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг боловсруулах

4.6.4.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх

4.6.5.Нөөц нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед санал боловсруулж сумын Засаг даргад танилцуулах

4.6.6.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид хортон шавьжтай тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах

4.6.7.Бэлчээрийн даац, багтаамжийн дүнд тулгуурлан тухайн жилд малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, хэмжээ, сүргийн эргэлтийг оновчтой зохион байгуулж, мал аж ахуйг үр ашигтай эрхлэн явуулахад тоонд бус чанарт анхаарч өндөр ашиг шимтэй сумын цөм сүргийг бий болгож, малчид болон малчдын бүлэгт эцэг мал нийлүүлэх замаар шийдвэрлэх

4.7.Сумын цаг уурын харуул дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
4.7.1.Фотомониторингийн цэгийн тоо, бэлчээрийн даац тодорхойлсон дүнгийн хамт жил бүрийн 8 дугаар сарын 20-ны дотор сум, багийн Засаг даргад хүргүүлэх

4.7.2.Цаг агаарын урьдчилсан мэдээллээр хангах, масс мэдээ илгээх

4.8.Газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.8.1.Малчин (бүлэг)-тэй бэлчээр, ус ашиглалтын гэрээ байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргаж өгөх, газрын мэдээллийн нэгдсэн санд давхцуулахгүй бүртгэх, гэрээний хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сумын Засаг даргад тайлагнах

4.8.2.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахад оролцож багийн иргэдийн Нийтийн Хуралд саналаа хүргүүлэх

4.8.3.Газрын тухай хуулийн 58.5 заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх

Тав. Бэлчээрийг ашиглуулах

5.1.Бэлчээр ашиглагч малчин, малчдын бүлэг дараах үүрэг хүлээнэ.

5.1.1.Бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулахад биечлэн оролцох

5.1.2.Бэлчээр өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан сум, багийн Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх

5.1.3.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон шийдвэрийг мөрдөж, сум, багийн Засаг дарга, ИТХ-ын төлөөлөлгч нартай хамтран ажиллах.

5.1.4.Малын тоо толгойн татварыг сумын ИТХ-ын тогтоосон хэмжээгээр хуулийн хугацаанд төлөх

5.1.5.Гаднаас дур мэдэн отрын айл, мал сүргийг зөвшөөрөлгүй оруулж, өвөлжөө, хаваржаа, хот бууцыг дамжуулан ашиглуулахгүй, бэлчээр хашихгүй байх

5.1.6.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулахыг сумын Засаг дарга хуульд заасан эрхийн хүрээнд зохион байгуулж хяналт тавина. Шинээр хашаа, хороо барих, уст цэг гаргах, газар олгох, шилжүүлэх, бэлэглэхэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

5.1.7.Бэлчээр, хашаа, саравч, бууц, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй, малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, хортон мэрэгчтэй тэмцэх, сумын мал эмнэлгээр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, устгах

5.1.8.Бэлчээрийн даац хэтэрсэн тохиолдолд сумын Засаг дарга, багийн Засаг дарга, малчид зөвшилцөж,үр дүнд суурилсан хамтын шийдвэр гаргана.

5.1.9.Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаандаа зөвшөөрөлгүй бусад аймаг сумаас отроор ирсэн айл түрээсээр буулгахгүй байх

5.1.10.Хуц, ухна маллах суурийн зусах, намаржих газрыг багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.2.Өвөлжөө, намаржааны бүс нутгийг чөлөөлөх, бэлчээрийн худгийг нээх, хаах хугацаа:

5.2.1.Өвөлжингийн бүс нутагт байгаа бэлчээрийн худгийг ажиллуулах хугацаа: 12 дугаар сарын 01-ээс 05 дугаар сарын 01 хүртэл

5.2.2.Хаваржаа намаржааны бүст байрлах худгийн ажиллуулах хугацаа: 10 дугаар сарын 20-ноос дараа оны 06 дугаар сарын 01 хүртэл

5.3.Зуслан, өвөлжөө, хаваржаа, намаржааны бүс нутгийн зааг

5.3.1.Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6-д заасны дагуу тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталж, зуслан, өвөлжөө, хаваржаа, намаржааны бүс нутгийн заагийг тогтооно.Багийн иргэдийн нийтийн хурлаар шийдвэрлэгдсэн хил заагыг дагаж мөрдөнө.

5.4.Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй, хавар, намрын отрын бүс нутгийн хилийг давж отор нүүдэл хийсэн, бэлчээрийн худгийг нээх, хаах хугацааг зөрчих зэрэг нийтийн зориулалттай өмч, хүрээлэн байгаа орчны эсрэг зөрчил үйлдэх, шаардлага биелүүлээгүй дахин давтан үйлдсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож торгох арга хэмжээ авна.

5.5.Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас отор, нүүдэл хийгээгүй, сайн дурын үндсэн дээр бусад шалтгааны улмаас отор нүүдлээр ирсэн энэ журмын 4.2.7-т заасан бусад аймаг сумын малчин өрхөд харилцан тохиролцсоны үндсэн дээр бэлчээр ашиглуулсны төлбөр ногдуулна. Төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг үндэслэж тооцно.

5.6.Энэ журмын 2.2.3-д заасан зайд мал бэлчээхгүй, оторлохгүй, хашаа саравч барихгүй байх

5.7.Сумын төв дээр байнгын болон түр хугацаанд мал маллаж, тэжээж байгаа айл өрхүүд ойр орчны хогоо байнга цэвэрлэж, хог хаягдлын хураамж төлөх журамд заасан хэмжээгээр төлбөр төлнө.

Зургаа. Маргаан шийдвэрлэх хохирол нөхөн төлүүлэх

6.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

6.2.Журам зөрчсөн маргааныг сумын Засаг дарга шийдвэрлэнэ. Эс тохиролцсон тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6.3.Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

Долоо. Журам хүчин төгөлдөр болох

Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, «Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл»-д нийтэлсэний дараа хүчин төгөлдөр болно.

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Галшар сум

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын долоодугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолын заалтад “Сумын хэмжээнд мөрдөгдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифийг нэгдүгээр хавсралтаар” гэснийг “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хавсралтаар” гэж өөрчилсүгэй.

2.Тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Энхчулуун)-д даалгасугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авсан.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/491

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268¹ дүгээр зүйлийн 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дүгээр зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 10/11 шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” 680 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим хэрэгжүүлэх журам”-ын

2.4 дэх хэсгийн хүснэгтийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

д/д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх мэдүүлгийн горимын код
1	Барааг гаалийн баталгаат агуулахаас улс хоорондын тээврийн үйлчилгээнд гаргах	910	700-708
2	Монголын барааг улс хоорондын тээврийн үйлчилгээнд гаргах	911	шаардахгүй
3	Зорчигчид зориулан борлуулахаар татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулсан барааг улс хоорондын тээврийн төлбөртэй үйлчилгээнд гаргах	912	745-747

2.Мөн журмын 2 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсгийг нэмсүгэй:

“2.6.Улс хоорондын зорчигч тээвэрлэгч нь олон улсын аяллын хуваарийг урьдчилан гарган өгсөн тохиолдолд аяллын үйлчилгээнд зарцуулсан бараа, материалын норм хэмжээ болон зарцуулалтын тайланг үндэслэн сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон нэгтгэж, дараа сарийн гуравны өдрийн дотор бүрдүүлэлтийг хийнэ.”

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавих, харьяа гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлэх, гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн)-т, Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т үүрэг болгосугай.

4.Гаалийн бүрдүүлэлтийн горимын шинээр батлагдсан кодыг CAIS системийн ангилалтын санд оруулахыг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

5.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа гаалийн газар, хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ